

“СОЁЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ” ДЭД ХӨТӨЛБӨР

Нэгдүгээр бүлэг. Ерөнхий мэдээлэл

ЮНЕСКО-гоос “соёл”, “хөгжил” хоёрын хоорондын харилцан хамаарлыг тодорхойлохыг зорьж, соёлыг хөгжлийн бодлогын чухал хэсэг болохыг хүлээн зөвшөөрч эхэлсэнтэй холбогдуулан соёлын үйлдвэрлэлийн эдийн засгийн ач холбогдол дэлхий нийтийн хэмжээнд улам бүр нэмэгдэж байна.

Соёлын үйлдвэрлэлийн олон янзын үзэл баримтлал болон олон улсын туршлагаас харахад “соёлын үйлдвэрлэл”, “бүтээлч үйлдвэрлэл”, “соёлд суурилсан бүтээлч үйлдвэрлэл”, “чөлөөт цагт зориулсан үйлдвэрлэл” зэргээр нэршин томъёолж байгаа ч дэлхий нийтэд эдгээрийн талаарх нэгдсэн нэг ойлголт, албан ёсны тодорхойлолтод хүрээгүй байгаа бөгөөд улс орнууд өөрсдийн үндэстний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан үйлдвэрлэл, үйлчилгээг зохиогчийн эрх, инновацид тулгуурлан, бизнес, хөрөнгө оруулалтын дэмжлэгтэйгээр олон улсын болон дотоодын зах зээлд соёлын үйлдвэрлэлийг өргөжүүлэн, түүний эдийн засаг, нийгэмд оруулах бодит үр өгөөжийг нь хүлээн зөвшөөрч, улам бүр дэмжин хөгжүүлэх зорилт тавин хэрэгжүүлж байна.

Манай улсын хувьд улс, үндэстнийхээ арвин баялаг өв уламжлал, ёс заншил, соёлын онцлог, байгалийн өвөрмөц дүр төрх, соёлын нөлөөг сэргээх, хайрлан хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах, дэлхий нийтэд таниулах, сурталчлах арга хэмжээ авч, өөрийн орны нөөц, бололцоонд тулгуурлан соёлын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх зорилгоор “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийг баталсан.

“Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.4-т “Улаанбаатар хотын нэрийн хуудас болсон соёлын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааг дэмжиж, эдийн засгийн эргэлтэд оруулах “Соёлын үйлдвэрлэл” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэж тусгасан. Нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит соёл, урлагийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж, үйлдвэрлэл эрхлэгчдэд бодлогын хувьд дэмжлэг үзүүлэх боломжийг эрэлхийлж, энэхүү “Соёлын үйлдвэрлэл” дэд хөтөлбөрийг боловсруулсан болно.

Хоёрдугаар бүлэг. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Хөтөлбөрийн зорилго нь үндэсний соёл уламжлал, монгол хүний оюуны бүтээлийг инноваци, зохиогчийн эрхэд тулгуурлан эдийн засгийн эргэлтэд оруулж, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар түүний нөлөөг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг нийслэлийн хэмжээнд өрнүүлэхэд оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлж байна:

2.2.1. Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.2.2. Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах;

2.2.3. Соёл, урлагийн байгууллагын хөрвөх чадварыг нэмэгдүүлж, Соёлын үйлдвэрлэлийг кластерийн зарчмаар хөгжүүлэх;

2.2.4. Оюуны өмчийн эрхийг хамгаалах, баталгаажуулах арга хэмжээг нийслэлийн хэмжээнд авч хэрэгжүүлэх;

Гуравдугаар бүлэг. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа

3.1. Хөтөлбөрийг 2017-2020 он хүртэл нэг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.2. Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:

3.2.1. Соёлын үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн бүртгэл-мэдээллийн сан бий болгох;

3.2.2. Соёлын статистикийг олон улсын аргачлалын дагуу Нийслэлийн Соёл, урлагийн салбарт нэвтрүүлэх;

3.2.3. Бичил бизнес эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн соёлын шинж чанартай бэлэг, дурсгалын бүтээгдэхүүнийг брэнд бүтээгдэхүүн болгон нийслэлийн онцлогтой бэлэг дурсгалын зүйлсийг бий болгох;

3.3. Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах зорилтын хүрээнд:

3.3.1. Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар судлаачдын баг, судалгааны байгууллагуудтай хамтран эрдэм шинжилгээний ажил, сургалт, семинар, форум, үзэсгэлэн яармаг зохион байгуулах;

3.3.2. Соёл, урлагийн ажилтан, албан хаагчдын англи хэлний мэдлэгийг анхан шатнаас гүнзгий, ахисан түвшинд хүргэх сургалтуудыг зохион байгуулж, гадаад улс оронд мэргэших боломжийг нэмэгдүүлэх;

3.3.3. Ерөнхий боловсролын сургуулиудын урлаг заал, танхимд соёл, урлагийн үйл ажиллагаа явуулахдаа тухайн нэгжийн санал дээр үндэслэн зохион байгуулах, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр иргэд, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран соёлын олон талт үйл ажиллагаа явуулах

3.4. Соёл, урлагийн байгууллагын хөрвөх чадварыг нэмэгдүүлж, Соёлын үйлдвэрлэлийг кластерийн зарчмаар хөгжүүлэх зорилтын хүрээнд:

3.4.1. Дүүргүүдийн Соёлын ордны үйл ажиллагааг шинэчилж, үйлчилгээний цар хүрээг өргөтгөх замаар соёлын олон талт үйлчилгээг нэвтрүүлж, энтертайнмент төв хэлбэрээр хөгжүүлэх;

3.4.2. Нийслэлийн “Улаанбаатар” чуулгыг түшиглэн залуучуудад зориулсан орчин үеийн урлагийн инкубатор төвийг байгуулах;

3.4.3. Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт Соёлын асуудал хариуцсан мэргэжлийн хүний нөөцийг бий болгох

3.5. Оюуны өмчийн эрхийг хамгаалах, баталгаажуулах арга хэмжээг нийслэлийн хэмжээнд авч хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

3.5.1. Мэргэжлийн урлагийн байгууллагуудад зохион байгуулагдах уран бүтээл, тоглолт, соёлын үйл ажиллагаанд Зохиогчийн эрхээр баталгаажсан Соёл, урлагийн бүтээлийг борлуулах журмыг боловсруулж, мөрдүүлэх;

3.5.2. Соёлын үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах “Соёлын үйлчилгээний стандарт”-ыг боловсруулж, мөрдүүлэх;

Дөрөвдүгээр бүлэг. Хөтөлбөрийн үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр нөлөөг бий болгоно.

Инноваци, зохиогчийн эрхэд тулгуурласан үндэсний соёл, уламжлал, оюуны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг эдийн засгийн эргэлтэд оруулж, нийслэлийн хэмжээнд соёлын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг кластерийн зарчмаар дэмжиж ажиллана.

4.2. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн: “Соёлын үйлдвэрлэл” дэд хөтөлбөрийг соёлын олон төрөл, зүйл дотроос мэдлэг, нэмүү өртгийг шингээн инноваци, соёлын боловсрол, зохиогчийн эрхэд суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах боломж, нөхцөлийг харгалзан дараах бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

- Дэлгэцийн урлаг (бүх төрлийн кино);
- Дизайн, дүрслэх урлаг (хувцас загвар, дизайн, гар урлал, уран зураг);
- Тайзны уран бүтээл (урлагийн тоглолт, үзүүлбэр);

- Хөгжмийн үйлдвэрлэл (Хөгжмийн зэмсэг, хөгжмийн уран бүтээл);
- Соёлын өв, уламжлал, зан заншил, соёлын аялал жуулчлал;
- Зохиогчийн эрхийг хамгаалсан соёлын үйлчилгээ (Караоке, сургалт, цэнгээнт үйлчилгээ)

4.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:

№	Бодлогын баримт бичгийн бүлэг/заалт	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин	
					Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт
"Соёлын үйлдвэрлэл" дэд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд								
1.	2.2.1.	Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийг дэмжсэн байдал	Тоо	2017	-	2020	20
2.	2.2.2.	Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах	Мэргэжлийн хүний нөөц бүрдүүлсэн байдал	Тоо	2017	1 дүүрэг буюу 11 хувь	2020	9 дүүрэг буюу 100 хувь
3.	2.2.3.	Соёл, урлагийн байгууллагын хөрвөх чадварыг нэмэгдүүлж, Соёлын үйлдвэрлэлийг кластерийн зарчмаар хөгжүүлэх	Менежментийг сайжруулсан байгууллага	Тоо	2017	-	2020	4 соёл, урлагийн байгууллага буюу 50 хувь
4.	2.2.4.	Оюуны өмчийн эрхийг хамгаалах, баталгаажуулах арга хэмжээг нийслэлийн хэмжээнд авч хэрэгжүүлэх	Зохиогчийн эрхийг хамгаалсан эрх зүйн орчин бүрдүүлсэн байдал	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	2017	-	2020	Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн урлагийн 5 байгууллагыг хамруулсан байна.

Тавдугаар бүлэг. Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр

5.1. Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1.1. Улсын төсөв;

5.1.2. Орон нутгийн төсөв;

5.1.3. Гадаадын болон хувийн хэвшлийн зээл, тусламж, хөрөнгө оруулалт;

5.1.4. Бусад эх үүсвэр.

Зургаа. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт- шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө

6.1. Нийслэлийн Соёл, урлагийн газар хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан, хэлэлцүүлнэ.

6.2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс дэд хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг бүхэлд нь хамруулан хэрэгжилтийн явцад жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

6.3. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан хоёр жил тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

6.4. Нийслэлийн Соёл, урлагийн газар хяналт-шинжилгээ, үнэлгээний санал зөвлөмжийн дагуу цаашид авч хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

-----oO-----

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах
нийтлэг журмын 1 дүгээр хавсралт

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН УЯЛДАА
(Бодлогын хувилбар бүрээр)

№	Боловсруулж байгаа бодлогын баримт бичгийн зорилго, зорилт	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	Төрөөс Соёлын талаар баримтлах бодлого	Соёлын үйлдвэрлэл үндэсний хөтөлбөр	Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
		Нийцэж байгаа зорилго, зорилт	Нийцэж байгаа зорилго, зорилт	Нийцэж байгаа зорилго, зорилт	Нийцэж байгаа зорилго, зорилт
1.	Зорилго: Үндэсний соёл уламжлал, монгол хүний оюуны бүтээлийг инноваци, зохиогчийн эрхэд тулгуурлан эдийн засгийн эргэлтэд оруулж, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар түүний нөлөөг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг нийслэлийн хэмжээнд өрнүүлэхэд оршино.	2.1.2. Монгол Улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болно. I үе шат (2016 -2020): Байгаль, соёлын өвийн үйлдвэрлэл, үзмэрүүдийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын онцлог дүр төрхийг бүрдүүлэх,	4.1.8.соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж соёлын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, соёл, урлагийн зах зээлийг өргөжүүлэхэд салбар хоорондын уялдаа, холбоог сайжруулах	2.1. Хөтөлбөрийн зорилго нь үндэсний соёл уламжлал, монгол хүний оюуны бүтээлийг инноваци, зохиогчийн эрхэд тулгуурлан эдийн засгийн эргэлтэд оруулж, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар монгол соёлын нөлөөг дэлхий нийтэд сурталчлан таниулахад оршино.	4.3.4. “Улаанбаатар хотын нэрийн хуудас болсон соёлын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдааг дэмжиж, эдийн засгийн эргэлтэд оруулах “Соёлын үйлдвэрлэл” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ”
2.	Зорилт 1: Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	2.1.7. Худалдаа, үйлчилгээг хөнгөвчлөх, экспорт, импортын барааны тээвэрлэлтийн ложистик сүлжээг хөгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулах, татвар төлөлтийн болон улсын цахимжуулж,	4.2.5.соёлын чиглэлээр жижиг, дунд үйлдвэр байгуулж ажиллуулах иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн санал санаачлагыг дэмжих;	3.1.1. соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх, санхүү, хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;	4.3.4. “Улаанбаатар хотын нэрийн хуудас болсон соёлын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдааг дэмжиж, эдийн засгийн эргэлтэд оруулах “Соёлын үйлдвэрлэл” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ”

		боловсронгуй болгон бизнес эрхлэлтийн орчныг төгөлдөршүүлнэ.			
3.	Зорилт 2: Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах		4.2.7.соёлын ажилтны нийгмийн баталгааны асуудлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үүнийг шийдвэрлэхэд нь бодитой туслалцаа дэмжлэг үзүүлэх, орон нутгийн соёл, урлагийн байгууллагыг мэргэжлийн ажилтнаар бүрэн хангаж, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нэмэгдэл цалин олгох, урамшуулал үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;	3.1.2. соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах;	4.3.4. “Улаанбаатар хотын нэрийн хуудас болсон соёлын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдааг дэмжиж, эдийн засгийн эргэлтэд оруулах “Соёлын үйлдвэрлэл” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ”
4.	Зорилт 3: Соёл, урлагийн байгууллагын хөрвөх чадварыг нэмэгдүүлж, Соёлын үйлдвэрлэлийг кластерийн зарчмаар хөгжүүлэх	Зорилт 1.Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх	4.1.1.соёл, урлагийн салбарт оновчтой, бие даасан, тогтвортой бүтэц бий болгож, удирдлага, зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгох	3.1.3. соёлын үйлдвэрлэлийг кластерийн зарчмаар хөгжүүлэхэд шаардлагатай барилга байгууламжийг бий болгох, техник, тоног төхөөрөмжөөр хангах	4.3.4. “Улаанбаатар хотын нэрийн хуудас болсон соёлын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдааг дэмжиж, эдийн засгийн эргэлтэд оруулах “Соёлын үйлдвэрлэл” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ”
5.	Зорилт 4: Оюуны өмчийн эрхийг хамгаалах, баталгаажуулах арга хэмжээг нийслэлийн хэмжээнд авч хэрэгжүүлэх	2.2 Нийгмийн тогтвортой хөгжил Монгол хүний хөдөлмөрийн	4.2.12.хэвлэл мэдээллийн хэрэгслийн соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, нийтлэл,	3.1.5. оюуны өмчийн эрхийг хамгаалах, баталгаажуулах арга хэмжээг үндэсний болон олон улсын	4.3.4. “Улаанбаатар хотын нэрийн хуудас болсон соёлын бүтээгдэхүүн үйлдвэрлэл,

		үнэлэмжийг бүтээмжид суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоонд шилжүүлэх;	нэвтрүүлгийн ёс зүйн хэм хэмжээнд тавих шаардлагыг дээшлүүлж, утга зохиол, урлагийн бүтээл зохиогчийн эрхийг хүндэтгэн хамгаалах, соёлын үйл ажиллагааг зохистой, тэнцвэртэй сурталчилж, хүн амын эрэлт, хэрэгцээг хангах	хэмжээнд авч хэрэгжүүлэх;	худалдааг дэмжиж, эдийн засгийн эргэлтэд оруулах “Соёлын үйлдвэрлэл” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ”
Нийт	16	4	5	5	1
Нийцсэн (тоо, %)	100%	80%	100%	100%	100%

Тайлбар танилцуулга:

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 509 дүгээр тогтоолоор батлагдсан “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийслэлд хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг Монгол Улсын төрөөс Соёлын талаар баримтлах бодлого, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулсан болно. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тодорхой нийцсэн заалт ховор байгаа бөгөөд УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын 4.6-д “Үндэсний соёлыг эрчимтэй хөгжүүлэх эдийн засаг, зохион байгуулалтын тааламжтай орчин бүрдүүлнэ” гэсэн Стратегийн зорилт 1, “Хүн амд соёл, урлагийн үйлчилгээг хүртээмжтэй чанартай хүргэж, иргэдийн оюуны хэрэгцээг хангах талаар дорвитой ахиц гаргана” гэсэн Стратегийн зорилт 2-той нийцсэн гэж үзэж байна.

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах
нийтлэг журмын 2 дугаар хавсралт

**ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХУВИЛБАР БҮРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД
ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮГИЙН ЭХ
ҮҮСВЭРИЙН ТӨСӨӨЛӨЛ ТООЦОО (Хувилбар бүрээр)**

(Сая төгрөгөөр)

№	Бодлогын зорилго, зорилт	Эхлэх/дуу сах огноо	Нийт (1+2+ 3+4)	Төсвийн жил (2017)			Төсвийн жил (2018)			Төсвийн жил (2019)			Төсвийн жил (2020)		
				Нийт шаардагдах санхүүжилт	Урсгал зардал	Хөрөнгө оруулалт	Нийт шаардагдах санхүүжилт	Урсгал зардал	Хөрөнгө оруулалт	Нийт шаардагдах санхүүжилт	Урсгал зардал	Хөрөнгө оруулалт	Нийт шаардагдах санхүүжилт	Урсгал зардал	Хөрөнгө оруулалт
1. Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилт															
1	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас болон нийслэлийн төрийн захиргааны байгууллагуудаас гадаад, дотоодын зочид, төлөөлөгчдөд үндэсний хэв шинж, онцлогийг агуулсан гарын бэлэг, дурсгалын зүйлс бэлэглэж байх чиглэлээр санаачлага өрнүүлж хэрэгжүүлэх	2017-2020	3.0				1.0	1.0		1.0	1.0		1.0	1.0	
2	Соёлын үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн талаар бүртгэл-мэдээллийн сан бий болгох	2017-2020	3.0				2.5		2.5	0.5		0.5			
7	Соёлын үйлдвэрлэлийг эрхлэгч, шилдэг контент, соёлын бүтээлч үйлдвэрлэгчдийг нэрлэж, алдаршуулах	2017-2020	3.0				1.0	1.0		1.0	1.0		1.0	1.0	
2. Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах зорилт															
	Соёлын	2017-2020	3.0	0.0	0.0		1.0	1.0		1.0	1.0		1.0	1.0	

<p>үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар судлаачдын баг, судалгааны байгууллагуудтай хамтран эрдэм шинжилгээний ажил, сургалт, семинар, форум, үзэсгэлэн яармаг зохион байгуулах</p>															
<p>Соёл, урлагийн ажилтан, албан хаагчдын англи хэлний мэдлэгийг анхан шатнаас гүнзгий, ахисан түвшинд хүргэх сургалтуудыг зохион байгуулж, гадаад улс оронд мэргэших боломжийг нэмэгдүүлэх</p>	2017-2020	4.5				1.5	1.5		1.5	1.5		1.5	1.5		
<p>Мэдлэг, туршлагаа хуваалцах клуб, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний төвүүдийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх</p>	2017-2020	7.0				1.0		1.0	3.0		3.0	3.0	3.0		
<p>Ерөнхий боловсролын сургуулиудад суралцаж буй авьяаслаг сурагчдын дунд олон талт соёл, урлагийн тэмцээн уралдаан, хөгжүүлэх сургалт, олимпиад зэргийг тогтмол зохион байгуулах, соёлын боловсролыг дээшлүүлэх төсөл</p>	2017-2020	5.0				1.0	1.0		2.0	2.0		2.0		2.0	

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах
нийтлэг журмын 3 дугаар хавсралт

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛЫН БАГЦ

№	Бодлогын баримт бичгийн холбогдох зорилго, зорилт	Байгууллага, хувь хүн	Санал гаргасан				Тусгасан эсэх (Тайлбар үндэслэл)
			Нэмэлт оруулах	Хасах	Өөрчлөх	Найруулах	
1	“Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх” зорилт	Нийслэлийн Боловсролын газар	ЕБС-ын сургуулийн сурагчид, дизайн технологийн багш нарын урлан бүтээсэн үндэсний хэв шинж, онцлогийг агуулсан бэлэг дурсгалын зүйлс, цэцэрлэгийн хүүхдэд зориулсан тоглоом, наадгайн үзэсгэлэн гаргах, тэднээс худалдан авах				Тийм . Соёлын үйлдвэрлэлийн чиглэлийн үзэсгэлэн, форум зохион байгуулах үйл ажиллагаа орсон байгаа тул агуулгын хувьд давхацсан гэж үзсэн
		Нийслэлийн үйлдвэрлэл, инновацийн газар	Монгол хүүхэд, залуусын үлгэрлэн дуурайх баатрын дүрийг судлан гаргаж, бэлэг дурсгал, тоглоом, кино, тайз, дэлгэцийн бүтээл болгох, соёлын бараа, хүнсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжин сурталчлах; Хотын аялалын шинэ төрөл, чиглэл, маршрут гарган аялал зохион байгуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах;			Хамтран ажиллах санал ирүүлсэн.	Үгүй. Хамтран ажиллах санал болон “Найрсаг дэм” төслийн саналыг ирүүлсэн бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад тодорхой ажил болгон явах боломжтой гэж үзсэн.
		Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар	Бичил бизнес эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн соёлын шинж чанартай бэлэг, дурсгалын бүтээгдэхүүнийг брэнд бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх				Бичил бизнес эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн соёлын шинж чанартай бэлэг, дурсгалын

						бүтээгдэхүүнийг брэнд бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх	
			<ul style="list-style-type: none"> - Гадаадаас буцан ирэгсдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин соёлын чиглэлээр шинэ санаа, дэвшилтэт технологийг нутагшуулах, мэдээлэл солилцох арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах - Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад хотын болон өв соёлын талаар сургалт зохион байгуулах боломжийг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх 				Үгүй. Хөтөлбөрийн зорилгын агуулгын хүрээнд хамааралгүй гэж үзсэн.
	Олон Улсын Оюун ухааны музей	<ul style="list-style-type: none"> - Хувийн музей, галлерей, соёлын өвийг тээгчдийг дэмжих туслах талаар арай өргөн хүрээтэй ажлууд оруулмаар - Соёлын үйлдвэрлэлд оруулж буй хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрх хамгаалалт, бүртгэл судалгаа, үйл ажиллагаагаар нь олгодог төрөл бүрийн урамшуулал бий болгох - Жуулчдын талаар авах арга хэмжээний бодлого, хөтөлбөр, маршрутад оруулах, гадаад дотоодын үзэсгэлэн яармагт хөнгөлөлттэй нөхцөлөөр оруулж байх - Эрт эдүгээгийн соёлын өвийн цуглуулгатай хүмүүсийг судалж музей байгуулах 			Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас болон нийслэлийн төрийн захиргааны байгууллагуудаас гадаад, дотоодын зочид, төлөөлөгчдөд үндэсний хэв шинж, онцлогийг агуулсан гарын бэлэг, дурсгалын зүйлс бэлэглэж байх чиглэлээр санаачлага өрнүүлж, хэрэгжүүлэх;	Тийм.	

			<p>зорилго, сонирхолтой цуглуулагчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр байр, газар өгөх зэргээр бодит тусалцаа үзүүлж байх</p> <p>- Хот, шат шатны байгууллагуудын ажилтнууд гадаад дотоодын зочид төлөөлөгчдөөр сайн ажил үйлчилгээ явуулж буй хувийн музей, галлерейг зохион байгуулалт бодлого чиглэлтэйгээр үзүүлж байх, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчлах, туршлага үйл ажиллагааг нь дэлгэрүүлэх олон талын ажил зохион байгуулах</p> <p>- Соёлын үйлдвэрлэл явуулж буй байгууллагуудад өөрийн онцлогтой бэлэг дурсгалын зүйлийн захиалга өгч олон тоогоор үйлдвэрлэх боломжийг бий болгох, гадна дотны хурал цуглааны төлөөлөгчдөд болон гадны улс орнуудад явахдаа бэлэг дурсгалаа уг байгууллагуудаас авч байх зохион байгуулалтын арга хэмжээ авах.</p>				
		Соёлын өвийн төв	<p>- Соёлын өвийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн болон өвлөн уламжлагчын оролцоог нэмэгдүүлэх чиглэлд үйл ажиллагааг тусгах</p>				<p>Үгүй. Соёлын өвд ээлтэй Улаанбаатар аяны хүрээнд соёлын өвийн чиглэлд шийдвэрлэх санал тус дэд хөтөлбөрт тусгаагүй.</p>

2	“Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах” зорилт	Нийслэлийн Боловсролын газар		Ерөнхий боловсролын сургуулиудын урлаг заал, танхимыг соёл, урлагийн чиглэлээр мэргэшсэн иргэн, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран соёлын олон талт үйл ажиллагааг явуулж, байнгын ажиллагааг сайжруулах	Ерөнхий боловсролын сургуулиудын урлаг заал, танхимд соёл урлагийн үйл ажиллагааг явуулахдаа тухайн нэгжийн санал дээр үндэслэн зохион явуулах, хамтын ажиллагааг сайжруулах	Ерөнхий боловсролын сургуулиудын урлаг заал, танхимд соёл, урлагийн үйл ажиллагаа тухайн нэгжийн санал дээр үндэслэн зохион байгуулах, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр мэргэшсэн иргэн, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран соёлын олон талт үйл ажиллагаа явуулах	Тийм
		СУИС, Соёл урлаг судлалын хүрээлэн	<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн судалгааны байгууллага болон мэргэжлийн судлаачдын багтай хамтарч ажиллах - Суурь судалгааны болон сурталчилгааны зориулалт бүхий ном бүтээл дэмжих, орчуулж хэвлүүлэх 		Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх эрдэм шинжилгээний ажил, сургалт, семинар, форум, үзэсгэлэн яармаг зохион байгуулах	Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар судлаачдын баг, судалгааны байгууллагуудтай хамтран эрдэм шинжилгээний ажил, сургалт, семинар, форум, үзэсгэлэн яармаг зохион байгуулах;	Тийм
		Уянга Цогт Амгалан ХХК /Хөгжмийн зэмсэг үйлдвэрлэл /	<ul style="list-style-type: none"> - Их дээд сургуульд Хөгжим урлаач мэргэжил бий болгох 				Үгүй. Энэ саналыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага нь Болвсролын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага хариуцан шийдвэрлэдэг. Иймд

							дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн.
		Жонон хамтлаг /Хөгжмийн бүтээл /	- Мэргэжлийн урлагийн байгууллагад шинээр төгсөж буй мэргэжилтнүүдэд цалинтай дадлагажих боломж олгох.				Үгүй. Энэ саналыг Соёлын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага, Сангийн яам, засгийн газартай хамтран шийдвэр гаргаснаар шийдвэрлэх санал тул тусгаагүй.
		“Некст галакси” ХХК Баяржаргал /Хар сарнай хамтлаг Маадай/	- Гар урлалын гудамж, өргөн чөлөөг нэрлэж буй болгох				Тийм. Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх боломжтой санал тул дэд хөтөлбөрийн үйл ажиллагааны саналд тусгасан.
3	“Соёл, урлагийн байгууллагын хөрвөх чадварыг нэмэгдүүлж, Соёлын үйлдвэрлэлийг кластерийн зарчмаар хөгжүүлэх” зорилт	Нийслэлийн Боловсролын газар			Дүүргүүдийн Соёлын ордны үйл ажиллагааг шинэчилж, үйлчилгээний цар хүрээг өргөтгөх замаар соёлын олон талт үйлчилгээг нэвтрүүлж, энтертаймэнт төв хэлбэрээр хөгжүүлэх	Дүүргүүдийн Соёлын ордны үйл ажиллагааг ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, сургуулиас завсардсан хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авьяас чадварыг хөгжүүлэх, тэднийг дэмжихэд чиглүүлэх	Үгүй. Дүүргүүдийн Соёлын ордны үндсэн үйл ажиллагаа нь иргэдийн насны онцлогт тохирсон, сургуулиас завсардсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйл ажиллагаанууд явуулдаг тул хөтөлбөрт давхардуулж оруулах шаардлагагүй гэж үзсэн.
		НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс		Соёлын асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллагад соёлын үйлдвэрлэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Дүүргүүдийн			Тийм. Соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүд Биеийн тамир, спорт, эрүүл мэнд, боловсрол, төрийн бус байгууллага зэрэг нийгмийн салбарын давхар ажил үүрэг ихээр хариуцдагаас үүдэлтэйгээр дүүрэг,

				Засаг даргын Тамгын газарт Соёлын асуудал хариуцсан мэргэжилтнийг нийгмийн бусад салбарыг давхардуулж хариуцуулахгүй байхаар ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх			орон нутаг дахь соёлын салбарын ажил цалгардахад хүрдэг. Иймээс хөтөлбөрт тусгайлсан заалт оруулж дүүргүүдэд Соёлын асуудал хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг шинэчлүүлэх шаардлагатай гэж үзсэн.
4	“Оюуны өмчийн эрхийг хамгаалах, баталгаажуулах арга хэмжээг нийслэлийн хэмжээнд авч хэрэгжүүлэх” зорилт	Нийслэлийн Боловсролын газар	3.5.2. Мэргэжлийн урлагийн байгууллагуудад зохион байгуулагдах уран бүтээл, тоглолт, соёлын үйл ажиллагаанд Зохиогчийн эрхээр баталгаажсан Соёл, урлагийн бүтээлийг борлуулах журмыг боловсруулж, мөрдүүлэх		Хүүхдэд зориулсан уран бүтээл, тоглолт, ном, сурах бичигт оруулах бүтээлийн сонголтыг зохиогчийн эрхээр баталгаажсан бүтээлийг боловсруулах журмыг боловсруулж, мөрдүүлэх		Үгүй. Хүүхдэд зориулсан бүтээлийн асуудлыг Соёлын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага хариуцан шийдвэрлэдэг. Иймд дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн.
		Монголын зохиолч, хөгжмийн зохиолч, нийтлэлчдийн нийгэмлэг	Дуу хөгжмийн мэдээллийн сан бий болгох.				Үгүй. Монгол улсын хэмжээний мэдээллийн сан байгуулах нь Соёлын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага хариуцан шийдвэрлэдэг. Иймд дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн.
		Монголын зохиолч, хөгжмийн зохиолч, нийтлэлчдийн	Оюуны өмчийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай журмыг Нийслэлээс гаргаж мөрдүүлэх.				Тийм. Дэд хөтөлбөрийн 3.5.1. Мэргэжлийн урлагийн байгууллагуудад зохион байгуулагдах уран

		нийгэмлэг					бүтээл, тоглолт, соёлын үйл ажиллагаанд Зохиогчийн эрхээр баталгаажсан Соёл, урлагийн бүтээлийг борлуулах журмыг боловсруулж, мөрдүүлэх; гэж найруулан оруулсан
		“Юби Шэйф” ХХК /Бэлэг дургалын үйлдвэрлэл/	Оюуны өмчийн цахим бүртгэлийн систем нэвтрүүлэх				Үгүй. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллага хариуцан шийдвэрлэдх ажил тул дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн.

“СОЁЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН НӨЛӨӨЛЛИЙН
УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ

А. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр эдийн засгийн хөгжил, захиргааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө	
1. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нөлөө үзүүлэх зорилтот бүлэг болон бусад бүлэг	Инноваци, зохиогчийн эрхэд тулгуурласан үндэсний соёл, уламжлал, оюуны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг эдийн засгийн эргэлтэд оруулж, нийслэлийн хэмжээнд соёлын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг кластерийн зарчмаар дэмжиж ажиллана.
2. Эдийн засгийн хөгжил болон захиргааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө	Соёлын үйлдвэрлэл эрхэлж буй иргэд, төрийн бус байгууллагуудыг бодлогын хувьд дэмжих боломж нэмэгдэнэ. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нийслэлээс соёлын үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого тодорхой болж, үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнес, үйл ажиллагааг дэмжих орчин, нөхцөл бүрдэнэ.
3. Бусад мэдээлэл	Олон нийт, хэрэглэгчид рүү чиглэсэн үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, худалдан авах, хэрэглэх сэдлийг нэмэгдүүлж, соёлын үйлдвэрлэлийн ахуй нөхцөл боломжийг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн гаргана. Соёлын үйлдвэрлэл, бүтээлч санаачлагад хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах боломжийг нэмэгдүүлнэ.
Б. Дэд хөтөлбөрийн нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл	
1. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр ямар нөлөө үзүүлэхийг дараах байдлаар тодорхойлж байна: 1.1. Соёлын үйлдвэрлэл дэх хувь хүний бүтээлч сэтгэлгээ, ур чадвар, авьяас билэг, оюуны өмчийг дээдлэх; 1.2. Дэвшилтэт техник технологи, инновацид суурилсан соёлын үйлдвэрлэлийг дэмжих; 1.3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлж, олон нийтийн оролцоог хангах; 1.4. Кластерийн тогтолцоонд суурилсан соёлын үйлдвэрлэл эрхлэх орчин нөхцлийг бүрдүүлэх; 1.5. Зохиогчийн эрхийг хамгаалахад чиглэх	
Бусад мэдээлэл	Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Нийслэлийн иргэдийн нийтийн соёлд үндэсний үйлдвэрлэл, соёлын үйлдвэрлэлийн нөлөөг дээшлүүлнэ.
В. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж болон эрх зүйн тогтолцоонд үзүүлэх нөлөө	
1. Бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль, эрх зүйн акт	Соёлын тухай хуулинд соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар нэмэлт өөрчлөлт оруулах. 1996 онд батлагдсан Соёлын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, УИХ-аар батлуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд НСУГ-ын дарга ажиллаж байгаа бөгөөд холбогдох саналуудыг нийслэлийн хэмжээнд нэгтгэн БСШУСЯ-д хүргүүлэн ажиллаж байгаа.
2. Хариуцах байгууллага	Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам, Нийслэлийн Соёл, урлагийн газар
Г. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр одоогийн байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын(институцийн) тогтолцоонд үзүүлэх	

нөлөө	
<p>1.Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцох байгууллагууд</p>	<p>Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамнаас бодлого хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаануудыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас үйл ажиллагааны зохион байгуулалт болон шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлэнэ.</p> <p>Нийслэлийн Соёл, урлагийн газар, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төсөл хэлбэрээр гүйцэтгэн зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллана.</p> <p>Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, орон нутгийн болон улсын төсөвт соёл, урлагийн байгууллагууд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.</p> <p>Соёлын үйлдвэрлэл эрхлэгч төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуй нэгж, байгууллагууд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өөрийн үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүнээрээ оролцож төрийн байгууллагуудтай хамтран соёлын үйлдвэрлэлийг өргөн хүрээнд хөгжүүлнэ.</p>
<p>2.Төрийн удирдлагын үйл ажиллагаа, бүтцэд үзүүлэх нөлөө (шинээр бүтэц бий болох, өнөөгийн институцийг татан буулгах, эсхүл бүтцийг өөрчлөн байгуулах)</p>	-
<p>3.Хүний нөөцөд үзүүлэх нөлөө</p>	-

Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах
нийтлэг журмын 5 дугаар хавсралт

СОЁЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮСНЭГТ

№	Бодлогын баримт бичгийн бүлэг/заалт	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин		Мэдээллийн эх сурвалж	Хэрэгжүүлэх байгууллага
					Он	Үзүүлэлт	Он	Үзүүлэлт		
"Соёлын үйлдвэрлэл" дэд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд										
5.	2.2.1.	Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийг дэмжсэн байдал	Тоо	2017	-	2020	20		НСУГ НЗДТГ
6.	2.2.2.	Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах	Мэргэжлийн хүний нөөц бүрдүүлсэн байдал	Тоо	2017	1 дүүрэг буюу 11 хувь	2020	9 дүүрэг буюу 100 хувь		НСУГ Дүүргүүдийн ЗДТГ НЗДТГ БСШУСЯ
7.	2.2.3.	Соёл, урлагийн байгууллагын хөрвөх чадварыг нэмэгдүүлж, Соёлын үйлдвэрлэлийг кластерийн зарчмаар хөгжүүлэх	Менежментийг сайжруулсан байгууллага	Тоо	2017	-	2020	4 соёл, урлагийн байгууллага буюу 50 хувь		НСУГ Харьяа соёл, урлагийн байгууллагууд БСШУСЯ
8.	2.2.4.	Оюуны өмчийн эрхийг хамгаалах, баталгаажуулах арга хэмжээг нийслэлийн хэмжээнд авч хэрэгжүүлэх	Зохиогчийн эрхийг хамгаалсан эрх зүйн орчин бүрдүүлсэн байдал	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	2017	-	2020	Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн урлагийн 5 байгууллагыг хамруулсан байна.		НСУГ Соёл, урлагийн байгууллагууд БСШУСЯ

Хэрэгжүүлэх байгууллагуудыг хэрэгжилтийг хангах хариуцлагын эрэмбээр жагсаана.

“СОЁЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго		Үндэсний соёл уламжлал, монгол хүний оюуны бүтээлийг инноваци, зохиогчийн эрхэд тулгуурлан эдийн засгийн эргэлтэд оруулж, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар түүний нөлөөг сурталчлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг нийслэлийн хэмжээнд өрнүүлэх				
Үр нөлөө (Үр нөлөөний шалгуур үзүүлэлт)		Инноваци, зохиогчийн эрхэд тулгуурласан үндэсний соёл, уламжлал, оюуны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг эдийн засгийн эргэлтэд оруулж, нийслэлийн хэмжээнд соёлын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг кластерийн зарчмаар дэмжиж ажиллана. (Нийслэлийн онцлог, боломжид тулгуурласан соёлын үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн байдал)				
Үйл ажиллагааны чиглэл		Соёлын олон төрөл, зүйл дотроос мэдлэг, нэмүү өртгийг шингээн инноваци, соёлын боловсрол, зохиогчийн эрхэд суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах боломж, нөхцөлийг харгалзан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ				
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
1.	Бичил бизнес эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн соёлын шинж чанартай бэлэг, дурсгалын бүтээгдэхүүнийг	Үндэсний соёл, уламжлалд суурилсан нийслэлийн онцлогийг илтгэсэн бэлэг дурсгалын зүйлсийн судалгааг гаргаж, 20 бүтээгдэхүүний танилцуулга бэлтгэх	Бэлэг дурсгалын зүйлсийг бий болгосон байдал	НЗДТГ НСУГ Үйлдвэрлэл эрхлэгчид	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	2018 оны III сар
2.	брэнд бүтээгдэхүүн болгон нийслэлийн онцлогтой бэлэг дурсгалын зүйлсийг бий болгох	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас болон нийслэлийн төрийн захиргааны байгууллагуудаас гадаад, дотоодын зочид, төлөөлөгчдөд Монголд үйлдвэрлэсэн үндэсний хэв шинж, онцлогийг агуулсан гарын бэлэг, дурсгалын зүйлс бэлэглэж байх чиглэлээр санаачлага өрнүүлэх				2018 оны VI сар
3.		Монголд үйлдвэрлэсэн үндэсний хэв шинж, онцлогийг агуулсан гарын бэлэг, дурсгалын зүйлстэй болох				2018 оны IV сар
4.		Бичил бизнес эрхлэгч иргэдийн үйлдвэрлэсэн соёлын шинж чанартай бэлэг, дурсгалын бүтээгдэхүүнүүдээс брэнд бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх судалгааг гаргаж, сурталчлах				2018 оны VI сар

5.		Монголд үйлдвэрлэсэн соёлын үйлдвэрлэлийн үндэсний хэв шинж, онцлогийг агуулсан гарын бэлэг, дурсгалын зүйлсийг бэлэглэж хэвших				2019-2020
6.	Соёлын үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн бүртгэл-мэдээллийн сан бий болгох	Соёлын үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн талаар бүртгэл-мэдээллийн сангийн судалгааны ажил, сургалт зохион байгуулах	Бүртгэл мэдээллийн сан бий болсон байдал	НСУГ Дүүргүүдийн ЗДТГ	Үйлдвэрлэл эрхлэгчид	2018 оны II сар
7.		Бүртгэл-мэдээллийн санг жил бүр тогтмол баяжуулах				2018-2020
8.	Соёлын статистикийг олон улсын аргачлалын дагуу Нийслэлийн Соёл, урлагийн салбарт нэвтрүүлэх	ЮНЕСКО-гийн Соёлын статистикийн хүрээний талаарх сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтарч явуулах	Соёлын статистикийн олон улсын аргачлал нэвтрүүлсэн байдал	НСУГ	ЮНЕСКО-гийн МҮК НСГ БСШУСЯ	2018 оны II сар
9.		ЮНЕСКО-гийн Соёлын статистикийн хүрээний талаарх судалгааны ажлыг өрнүүлэх				2018 оны III-X сар
10.		Соёлын статистикийг олон улсын аргачлалын дагуу Нийслэлийн Соёл, урлагийн салбарын статистик мэдээллийг боловсруулах				2019-2020
11.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соёлын үйлчилгээнд хамруулах, үйлчилгээний болон орчны нөхцөл байдлыг сайжруулах талаар судалгаа хийж, холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгөх	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг соёлын үйлчилгээнд хамруулах үйлчилгээний болон орчны нөхцөл байдлыг сайжруулах төслийн ажлыг эхлүүлэх	Байгууллагын үйлчилгээний орчин, нөхцлийг сайжруулсан байдал	НСУГ-ын харьяа соёл, урлагийн байгууллагууд НСУГ	НЗДТГ Үйлдвэрлэл эрхлэгчид	2018 оны V сар
12.						2018 оны VIII сар
13.						2018 оны VIII сар
14.	Соёлын үйлдвэрлэл эрхлэгч, шилдэг контент, соёлын бүтээлч үйлдвэрлэгчдийн судалгаанд үндэслэн салбарын болон нийтийн санал асуулга өрнүүлэх	Тухайн жилийн онцлох соёлын үйлдвэрлэл эрхлэгч, шилдэг контент, соёлын бүтээлч үйлдвэрлэгчдийг олон нийтэд танилцуулж, алдаршуулах	Шилдэг үйлдвэрлэл эрхлэгчдийг олон нийтэд танилцуулсан байдал	Хувийн хэвшлийн болон ТББ-ууд	НСУГ НЗДТГ	2018-2020 оны жил бүрийн XI сар
15.						
16.	Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар судлаачдын	Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар судлаачдын баг, судалгааны	Үйл ажиллагаа хэрэгжилт	Хувийн хэвшлийн	НСУГ СУИС	2018 оны XI сар

	баг, судалгааны байгууллагуудтай хамтран эрдэм шинжилгээний ажил, сургалт, семинар, форум, үзэсгэлэн яармаг зохион байгуулах	байгууллагуудтай хамтран эрдэм шинжилгээний ажил зохион байгуулах		болон ТББ-ууд		2018 оны VIII сар 2019 оны V сар
17.		Соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар судлаачдын баг, судалгааны байгууллагуудтай хамтран сургалт, семинар зохион байгуулах				2017-2020
18.		Соёлын үйлдвэрлэл эрхлэгчдийн саналыг үндэслэн төрөл бүрийн сургалтуудыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах				2017-2020
19.		Соёлын үйлдвэрлэлийн форум, үзэсгэлэн яармаг зохион байгуулах				2018-2019 оны VII сар
20.	Соёл, урлагийн ажилтан, албан хаагчдын англи хэлний мэдлэгийг анхан шатнаас гүнзгий, ахисан түвшинд хүргэх сургалтуудыг зохион байгуулж, гадаад улс оронд мэргэших боломжийг нэмэгдүүлэх	Соёл, урлагийн ажилтан, албан хаагчдын англи хэлний мэдлэгийг анхан шатнаас гүнзгий, ахисан түвшинд зохион байгуулах	Хүний нөөцийг чадавхижуулсан байдал	Хувийн хэвшлийн болон ТББ-ууд НСУГ	НСУГ НЗДТГ БСШУСЯ Судалгаа, шинжилгээний байгууллагууд СУИС	2018-2020
21.		Соёл, урлагийн ажилтан, албан хаагчдыг гадаад улс оронд мэргэшихэд дэмжлэг үзүүлэх				2018-2020
22.		Мэдлэг, туршлагаа хуваалцах клуб, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний төвүүдийг хөгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх				2018-2020
23.	Ерөнхий боловсролын сургуулиудын урлаг заал, танхимд соёл, урлагийн үйл ажиллагаа явуулахдаа тухайн нэгжийн санал дээр үндэслэн зохион байгуулах, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр иргэд, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран соёлын олон талт үйл ажиллагаа явуулах	Ерөнхий боловсролын сургуулиудад суралцаж буй авьяаслаг сурагчдын дунд олон талт соёл, урлагийн тэмцээн уралдаан, хөгжүүлэх сургалт, олимпиад зэргийг тогтмол зохион байгуулах, соёлын боловсролыг дээшлүүлэх төсөл хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт	НСУГ НБГ	НЗДТГ БСШУСЯ Соёл, урлагийн байгууллагууд ТББ-ууд	2017-2020
24.		Ерөнхий боловсролын сургуулиудын урлаг заал, танхимд соёл, урлагийн үйл ажиллагаа явуулахдаа тухайн нэгжийн санал дээр үндэслэн зохион байгуулах, хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр мэргэшсэн иргэн, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран соёлын олон талт үйл ажиллагаа явуулах				2018-2020
25.	Дүүргүүдийн Соёлын ордны	Дүүргүүдийн Соёлын ордны үйл ажиллагааг	Судалгааны	НСУГ	Хувийн	2017-2018

	үйл ажиллагааг шинэчилж, үйлчилгээний цар хүрээг өргөтгөх замаар соёлын олон талт үйлчилгээг нэвтрүүлж, энтертайммент төв хэлбэрээр хөгжүүлэх	шинэчилж, үйлчилгээний цар хүрээг өргөтгөх замаар соёлын олон талт үйлчилгээг нэвтрүүлж, энтертайммент төв хэлбэрээр хөгжүүлэх суурь судалгааг боловсруулах	ажлын дүгнэлт	Соёлын орднууд СУИС	хэвшлийн байгууллагууд ТББ-ууд	
26.		Дүүргүүдийн Соёлын ордны үйл ажиллагааг шинэчилж, үйлчилгээний цар хүрээг өргөтгөж энтертайммент төв болгох төслийг хэрэгжүүлж эхлэх				2018
27.		Дүүргүүдийн Соёлын ордныг соёлын үйлдвэрлэлийн кластерийн зарчмаар ажиллуулж, бүтээлч сэтгэлгээтэй иргэдийг дэмжиж ажиллах орон тооны бус зөвлөлийг ажиллуулах				2019 оноос
28.		Соёлын орднуудын танхим, өрөө тасалгааны ашиглалт, байнгын ажиллагааг нэмэгдүүлэхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудтай олон талт хамтын ажиллагаа өрнүүлэх				2018-2020
29.		Дүүргүүдийн Соёлын ордны үйл ажиллагаанд соёлын боловсрол олгох зорилтот төслүүдийг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх				2018-2020
30.	Нийслэлийн “Улаанбаатар” чуулгыг түшиглэн залуучуудад зориулсан орчин үеийн урлагийн инкубатор төвийг байгуулах	Нийслэлийн “Улаанбаатар” чуулгыг түшиглэн залуучуудад зориулсан орчин үеийн урлагийн инкубатор төвийг байгуулах төслийг боловсруулах	Төслийн хэрэгжилт	УБЧуулга НСУГ СУИС	НЗДТГ НЗХГ НАЖГ	2017
31.		Залуучуудын соёлын ордны үйл ажиллагааг Улаанбаатар чуулгын байранд давхар ажиллуулж, инкубатор төвийн үйл ажиллагааг эхлүүлэх				2018 оноос
32.		Гадаад, дотоодын жуулчдад зориулсан гар урлал, бэлэг дурсгал, үзвэр, үйлчилгээ бүхий соёлын цогц арга хэмжээг зохион байгуулах	Зохион байгуулсан үйл ажиллагааны хэрэгжилт	Үйлдвэрлэл эрхлэгчид НСУГ	НЗДТГ НАЖГ	2017-2020
33.	Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт Соёлын асуудал хариуцсан мэргэжлийн хүний нөөцийг бий болгох	Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт Соёлын асуудал хариуцсан мэргэжилтнийг нийгмийн бусад салбарыг давхардуулж хариуцуулахгүй байхаар ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх	Мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлсэн байдал	НСУГ Дүүргүүдийн ЗДТГ	НЗДТГ	2018 оны II сар

34.		Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт Соёлын асуудал хариуцсан мэргэжилтнийг соёл, урлагийн чиглэлээр сургууль төгссөн боловсон хүчнээр хангах талаар арга хэмжээ авах				2018 оноос
35.	Мэргэжлийн урлагийн байгууллагуудад зохион байгуулагдах уран бүтээл, тоглолт, соёлын үйл ажиллагаанд Зохиогчийн эрхээр баталгаажсан Соёл, урлагийн бүтээлийг борлуулах журмыг боловсруулж, мөрдүүлэх	Соёлын үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж, байгууллагуудад оюуны өмч зохиогчийн эрхийг хамгаалах, эдийн засгийн зөв хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр холбогдох хуулийг сурталчлах, сургалт, лекц зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилт	НСУГ УБОӨГ	НЗДТГ ТББ-ууд Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд	2017-2020
36.		Мэргэжлийн урлагийн байгууллагуудад зохион байгуулагдах уран бүтээл, тоглолт, соёлын үйл ажиллагаанд Зохиогчийн эрхээр баталгаажсан Соёл, урлагийн бүтээлийг борлуулах журмыг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, батлуулах	Журмын хэрэгжилт	НСУГ Мэргэжлийн холбоод	Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд БСШУСЯ	2018
37.		Мэргэжлийн урлагийн байгууллагуудад зохион байгуулагдах уран бүтээл, тоглолт, соёлын үйл ажиллагаанд Зохиогчийн эрхээр баталгаажсан Соёл, урлагийн бүтээлийг борлуулах журмын хэрэгжилтийг хангуулах				2018-2020
38.	Соёлын үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах “Соёлын үйлчилгээний стандарт”-ыг боловсруулж, мөрдүүлэх	Соёлын үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах “Соёлын үйлчилгээний стандарт”-ыг боловсруулах	Стандартын хэрэгжилт	НСУГ Мэргэжлийн холбоод	СХЗГ НЗДТГ БСШУСЯ Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд	2017 оны XI сар
39.	Соёлын үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад тавигдах “Соёлын үйлчилгээний стандарт”-ыг батлуулах	2018 оны IV сар				
40.	Стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах	2018 оны V сараас				